



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Дорнод Их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/41/СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
Чойбалсан хот	бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
2021 он	Утас: 7058-4203
	Аудитын менежер: И.Сэмжидмаа
	Утас: 7058-4207
	Аудитор: Э.Нандинчимэг
	Утас: 7000-3775
	Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a>
	Цахим хаяг: <a href="mailto:semjidmaai@audit.gov.mn">semjidmaai@audit.gov.mn</a>
	Цахим хаяг: <a href="mailto:khaanconsultingaudit@gmail.com">khaanconsultingaudit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

## Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	13
<b>Аудитын зөвлөмж</b> .....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	14
<b>4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ</b> .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОД ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Э.УНДАРМАА ТАНАА**

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрээн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.03.15 № 334

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод Их сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод Их сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод Их сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020175



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>903,940,520.83</b>	<b>904,677,350.97</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	98,489,918.80	32,456,148.75
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	98,047,382.10	32,456,148.75
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	98,047,382.10	32,386,449.20
31211	Төрийн сангийн харилцах	72,464,153.44	20,376,704.75
31212	Монгол банкин дахь харилцах	16,081,965.70	1,599,760.70
31213	Арилжааны банк дахь харилцах	7,535,958.00	9,864,533.75
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	1,737,210.00	326,150.00
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	219,300.00	219,300.00
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	-	69,699.55
31223	Арилжааны банк дахь харилцах	-	69,699.55
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	525,119,059.00	587,610,982.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,090,000.00	150,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	524,029,059.00	587,460,982.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	414,380,434.00	587,460,982.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	280,331,543.03	284,610,220.22
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	118,981,794.44	119,099,024.44
35110	Тусгай зориулалттай материал	118,981,794.44	118,981,794.44
35130	Эм боох материал	-	117,230.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	132,949,748.59	136,391,195.78
35410	Бичиг хэргийн материал	517,000.00	545,900.00
35420	Аж ахуйн материал	126,195,263.64	128,626,875.64
35430	Сэлбэг хэрэгсэл	-	144,500.00
35450	Барилгын засварын материал	-	8,000.00
35460	Хүнсний материал	119,434.95	780,070.14
35470	Бусад хангамжийн материал	6,118,050.00	6,285,850.00
35600	Мал амьтад	28,400,000.00	29,120,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,092,915,668.95</b>	<b>3,871,231,564.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,092,915,668.95	3,871,231,564.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,132,801,935.74	2,972,696,753.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,853,861,086.47	2,853,861,086.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(109,364,047.32)	(218,728,094.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,000,000.00	84,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,429,999.88)	(84,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	770,184,520.88	746,979,652.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(629,831,588.39)	(601,972,166.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	326,143,101.32	297,666,538.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(261,892,776.78)	(286,637,925.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	60,873,215.00	60,873,215.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,841,188.56)	(27,577,034.58)
39217	Ном	145,099,613.00	148,231,482.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	960,113,733.21	898,534,810.79
39301	Програм хангамж	95,621,733.00	34,185,810.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,032,999.79)	(5,175,999.71)
39303	Бусад биет бус хөрөнгө	869,525,000.00	869,525,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,996,856,189.78</b>	<b>4,775,908,914.97</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>29,890,363.80</b>	<b>213,711,820.24</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	29,890,363.80	213,711,820.24
<b>413</b>	<b>Өглөг</b>	29,890,363.80	213,711,820.24
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	29,890,363.80	78,711,820.24
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	135,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	135,000,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,966,965,825.98</b>	<b>4,562,197,094.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,966,965,825.98	4,562,197,094.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,338,938,878.95	2,338,938,878.95
51101	Өмч - төрийн	2,338,938,878.95	2,338,938,878.95
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	574,881,459.99	170,112,728.74
51210	Өмнөх үеийн үр дүн	574,881,459.99	574,881,459.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	(404,768,731.25)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,053,145,487.04	2,053,145,487.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,996,856,189.78</b>	<b>4,775,908,914.97</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,851,784,175.37</b>	<b>986,344,621.95</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,270,136,575.37</b>	<b>850,751,321.95</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,161,862,662.37	850,751,321.95
120002	Хүүгийн орлого	2,002,123.82	379,574.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,159,860,538.55	813,622,367.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	762,453,027.55	692,371,330.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	264,947,751.00	121,251,037.26
120009	Бусад орлого	-	36,749,379.80
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>308,129,700.00</b>	<b>135,593,300.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	303,134,700.00	135,593,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,925,872,202.66</b>	<b>1,281,464,728.20</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,925,872,202.66</b>	<b>1,281,464,728.20</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,907,887,120.99	1,276,360,022.20
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	969,859,337.00	766,901,998.28
210101	Үндсэн цалин	969,859,337.00	766,901,998.28
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	190,081,139.43	41,053,798.00
210201	Тэтгэврийн даатгал	151,285,551.43	31,200,886.48
210202	Тэтгэмжийн даатгал	9,698,897.00	656,860.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,939,779.00	2,627,443.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,397,794.00	6,568,607.68
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	108,215,390.00	79,478,111.29
210301	Гэрэл, цахилгаан	31,666,257.00	36,807,010.69
210302	Түлш, халаалт	54,888,721.00	37,147,995.60
210303	Цэвэр, бохир ус	21,660,412.00	5,523,105.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	82,269,621.54	36,506,171.56
210401	Бичиг хэрэг	18,174,434.30	10,163,408.20
210402	Тээвэр, шатахуун	10,869,832.00	4,393,969.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,124,638.51	4,834,528.36
210404	Ном, хэвлэл	691,355.00	765,780.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,165,372.00	1,699,670.00
210406	Бага үнэтэй, гүргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,243,989.73	14,648,816.00
2105	<b>Нормативт зардал</b>	96,909,789.05	27,963,583.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	737,543.00	465,300.00
210502	Хоол, хүнс	94,957,846.05	24,689,883.83
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,214,400.00	2,808,400.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,612,156.36	9,675,389.50
210604	Урсгал засвар	35,612,156.36	9,675,389.50
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	37,600,925.00	9,753,262.20
210701	Гадаад албан томилолт	13,100,220.00	1,639,000.00
210702	Дотоод албан томилолт	17,085,846.00	7,226,320.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,414,859.00	887,942.20
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	29,740,007.20	35,854,698.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,247,953.00	15,496,896.20
210803	Даатгалын үйлчилгээ	890,890.00	145,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,900.00	215,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,474,285.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	515,904.20	826,139.31
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	17,664,178.08
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	357,598,755.41	269,173,008.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,642,861.40	31,441,225.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,356,720.00	12,915,810.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	243,599,174.01	224,815,973.95
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,238,026.67	5,104,706.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,238,026.67	5,104,706.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,788,040.00	1,055,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,449,986.67	4,049,706.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(74,088,027.29)</b>	<b>(295,120,106.25)</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	109,648,625.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	109,648,625.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(109,648,625.00)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(74,088,027.29)</b>	<b>(404,768,731.25)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,574,546,891.37</b>	<b>1,067,421,667.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>992,899,291.37</b>	<b>931,828,367.95</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	992,899,291.37	931,828,367.95
120002	Хүүгийн орлого	2,002,123.82	379,574.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	990,897,167.55	644,582,213.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	593,964,116.55	519,665,782.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	266,031,751.00	124,916,431.26
120009	Бусад орлого	-	286,866,579.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>581,647,600.00</b>	<b>135,593,300.00</b>
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	303,134,700.00	135,593,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,642,080,394.21</b>	<b>1,130,323,569.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,642,080,394.21</b>	<b>1,130,323,569.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,624,091,399.21</b>	<b>1,125,187,363.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	969,859,337.00	723,508,050.06
210101	Үндсэн цалин	969,859,337.00	650,083,306.06
210102	Нэмэгдэл	-	68,739,959.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,684,785.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	164,618,329.23	41,053,798.00
210201	Тэтгэврийн даатгал	125,822,741.23	31,200,886.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,939,779.00	3,284,303.84
210205	Эрүүл мэндийн даатгал	19,397,794.00	6,568,607.68
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	108,215,390.00	79,404,611.29
210301	Гэрэл, цахилгаан	31,666,257.00	27,820,199.69
210302	Түлш, халаалт	54,888,721.00	46,061,306.60
210303	Цэвэр, бохир ус	21,660,412.00	5,523,105.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	67,235,052.78	31,197,126.26
210401	Бичиг хэрэг	15,944,824.00	7,071,059.80
210402	Тээвэр, шатахуун	10,869,279.40	4,931,909.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,127,482.51	4,704,528.36
210404	Ном, хэвлэл	4,173,402.00	669,193.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,168,999.50	1,603,073.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,951,065.37	12,217,363.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	96,887,621.30	25,241,701.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	734,210.00	587,307.00
210502	Хоол, хүнс	94,828,411.30	22,029,394.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,325,000.00	2,625,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,613,511.00	17,684,247.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	99,500.00
210602	Тавилга	-	1,377,000.00
210604	Урсгал засвар	35,613,511.00	16,207,747.10
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	37,601,314.40	9,715,643.50
210701	Гадаад албан томилолт	13,101,140.00	1,639,000.00
210702	Дотоод албан томилолт	17,085,859.40	5,838,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,414,315.00	2,238,043.50
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	30,691,757.20	147,750,458.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,249,703.00	11,847,326.40
210803	Даатгалын үйлчилгээ	840,890.00	145,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,900.00	57,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	255,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,903,615.00
210807	Газрын төлбөр	5,360.00	52,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	515,904.20	826,139.31
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	132,664,178.08

Дорнод Их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,369,086.30	49,631,726.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,252,266.30	34,042,746.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,116,820.00	15,588,980.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,241,940.00</b>	<b>5,136,206.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,241,940.00	5,136,206.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,788,040.00	1,086,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,453,900.00	4,049,706.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(67,533,502.84)</b>	<b>(62,901,901.05)</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>3,131,869.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>3,131,869.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,131,869.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,131,869.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b>(3,131,869.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(67,533,502.84)	(66,033,770.05)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	166,023,421.64	98,489,918.80
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,489,918.80	32,456,148.75

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,469,413,878.95</b>	<b>679,839,119.23</b>	<b>488,464,596.17</b>	<b>00.00</b>	<b>2,637,717,594.35</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,469,413,878.95</b>	<b>679,839,119.23</b>	<b>488,464,596.17</b>	<b>00.00</b>	<b>2,637,717,594.35</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-298,818,201.59	00.00	-298,818,201.59
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,338,938,878.95</b>	<b>2,053,145,487.04</b>	<b>574,881,459.99</b>	<b>00.00</b>	<b>4,966,965,825.98</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,338,938,878.95</b>	<b>2,053,145,487.04</b>	<b>574,881,459.99</b>	<b>00.00</b>	<b>4,966,965,825.98</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-404,768,731.25	00.00	-404,768,731.25
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,338,938,878.95</b>	<b>2,053,145,487.04</b>	<b>170,112,728.74</b>	<b>00.00</b>	<b>4,562,197,094.73</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,433,963,265.00	1,642,080,394.21	1,402,497,140.00	1,133,455,438.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,433,963,265.00	1,642,080,394.21	1,402,497,140.00	1,133,455,438.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,318,231,811.00	1,642,080,394.21	1,398,027,140.00	1,128,319,232.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	871,131,635.00	969,859,337.00	793,335,876.00	723,508,050.06
210101	Ундсэн цалин	871,131,635.00	969,859,337.00	691,497,402.00	650,083,306.06
210102	Нэмэгдэл	-	-	94,009,560.00	68,739,959.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	-
210104	Урамшуулал	-	-	808,914.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	7,020,000.00	4,684,785.00
2102	<b>Ажил олгогчөөс нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	164,618,329.23	103,366,984.00	41,053,798.00
210201	Тэтгэврийн даатгал	-	125,822,741.23	103,366,984.00	31,200,886.48
210202	Тэтгэмжийн даатгал	-	9,698,897.00	-	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	7,759,118.00	-	-
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,939,779.00	-	3,284,303.84
210205	Эрүүл мэндийн даатгал	-	19,397,794.00	-	6,568,607.68
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	104,793,365.00	108,215,390.00	105,217,080.00	79,404,611.29
210301	Гэрэл, цахилгаан	36,253,388.00	31,666,257.00	30,365,142.00	27,820,199.69
210302	Түлш, халаалт	49,209,367.00	54,888,721.00	50,755,748.00	46,061,306.60
210303	Цэвэр, бохир ус	19,330,610.00	21,660,412.00	24,096,190.00	5,523,105.00
210304	Байрны түрээс	-	-	-	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	70,664,400.00	67,235,052.78	50,590,800.00	34,328,995.26
210401	Бичиг хэрэг	16,490,800.00	15,944,824.00	11,912,200.00	7,071,059.80
210402	Тээвэр, шатахуун	9,548,800.00	10,869,279.40	5,366,600.00	4,931,909.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,898,800.00	6,127,482.51	8,139,000.00	4,704,528.36
210404	Ном, хэвлэл	16,400,000.00	4,173,402.00	4,120,000.00	3,801,062.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,620,000.00	1,168,999.50	2,220,000.00	1,603,073.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,706,000.00	28,951,065.37	18,833,000.00	12,217,363.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-	-	-
2105	<b>Нормативт зардал</b>	45,090,000.00	96,887,621.30	7,570,000.00	25,241,701.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	950,000.00	734,210.00	550,000.00	587,307.00
210502	Хоол, хүнс	36,000,000.00	94,828,411.30	2,600,000.00	22,029,394.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,140,000.00	1,325,000.00	4,420,000.00	2,625,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	81,259,980.00	35,613,511.00	24,620,000.00	17,684,247.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	820,000.00	-	420,000.00	99,500.00
210602	Тавилга	11,919,980.00	-	1,400,000.00	1,377,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	-	-
210604	Урсгал засвар	68,520,000.00	35,613,511.00	22,800,000.00	16,207,747.10
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	38,506,720.00	37,601,314.40	13,796,400.00	9,715,643.50
210701	Гадаад албан томилолт	15,797,420.00	13,101,140.00	5,420,000.00	1,639,000.00
210702	Дотоод албан томилолт	12,701,900.00	17,085,859.40	5,320,000.00	5,838,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,007,400.00	7,414,315.00	3,056,400.00	2,238,043.50
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	67,612,990.00	30,691,757.20	283,186,000.00	147,750,458.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,732,990.00	27,249,703.00	17,106,000.00	11,847,326.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	800,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	22,000,000.00	840,890.00	12,245,000.00	145,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	700,000.00	224,900.00	125,000.00	57,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,100,000.00	55,000.00	360,000.00	255,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,720,000.00	1,000,000.00	2,000,000.00	1,903,615.00
210807	Газрын төлбөр	100,000.00	5,360.00	100,000.00	52,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	450,000.00	515,904.20	450,000.00	826,139.31
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-	250,000,000.00	132,664,178.08
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,172,721.00	113,369,086.30	16,344,000.00	42,631,226.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	106,252,266.30	-	27,042,246.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,172,721.00	7,116,820.00	16,344,000.00	15,588,980.00
211	<b>ХҮҮ</b>	-	6,747,055.00	-	7,000,500.00
2111	<b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>	-	6,747,055.00	-	-
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	6,747,055.00	-	-
2112	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	-	-	-	7,000,500.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	7,000,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	115,731,454.00	11,241,940.00	4,470,000.00	5,136,206.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	115,731,454.00	11,241,940.00	4,470,000.00	5,136,206.00
213204	Ажил олгогчөөс олгох бусад тэтгэмж, урамшуулал	108,891,454.00	-	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	5,788,040.00	-	1,086,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,840,000.00	5,453,900.00	4,470,000.00	4,049,706.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,345,821,214.00	1,441,643,467.55	1,402,497,140.00	779,883,513.26
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	577,717,600.00	-	135,593,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-	-	135,593,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	-	304,199,700.00	-	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	273,517,900.00	-	-
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,345,821,214.00	858,930,867.55	1,402,497,140.00	644,582,213.26
1200041	Ундсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,182,114,750.00	592,899,116.55	990,927,975.00	519,665,782.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	163,706,464.00	266,031,751.00	161,569,165.00	124,916,431.26
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-	-	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорнод Их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Э.Ундармаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-аас 2021 оны 03 дугаар сарын 15-ы хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод Их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Дорнод Их сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр
- Магистрын зэрэг олгох хөтөлбөр
- Докторын зэрэг олгох хөтөлбөр

зэрэг хөтөлбөрүүдээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Дорнод Их сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дорнод Их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 783,080.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 11,746.2 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорнод Их сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 220,947.2 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, дансны авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	98,489.9	32,456.1	(66,033.7)
Дансны авлага	525,119.1	587,611.0	62,491.9
Бараа материал	280,331.5	284,610.2	4,278.6
Үндсэн хөрөнгө	5,205,308.3	5,095,322.8	(109,985.4)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(1,112,392.6)	(1,224,091.2)	(111,698.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,996,856.2</b>	<b>4,775,908.9</b>	<b>(220,947.2)</b>
Өр төлбөр	29,890.4	213,711.8	183,821.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,966,965.8	4,562,197.1	(404,768.7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,996,856.2</b>	<b>4,775,908.9</b>	<b>(220,947.2)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 32,456.1 мянган төгрөг болж 66,033.7 мянган төгрөгөөр буурсан нь онцгой нөхцөл байдлаас үүссэнээс хичээл сургалтын хэвийн үйл ажиллагаа тасарч үндсэн үйл ажиллагааны орлого багассантай холбоотой.

Дансны авлагын үлдэгдэл 587,611.0 мянган төгрөг болж 62,491.9 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын зээлийн сангаас оюутан хөгжлийн зээлийг олгоогүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 284,610.2 мянган төгрөг болж 4,278.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материал, сургалтын хэрэгсэл авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,095,322.8 мянган төгрөг болж 109,985.4 мянган төгрөгөөр буурсан нь шинээр 64,567.8 мянган төгрөгийн хичээлийн хэрэгслийн тоног төхөөрөмж худалдан авч, 84,640.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 28,476.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлтэйгөөр акталж, 61,436.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг биет бус хөрөнгөнд шилжүүлсэн байна.

Дорнод Их сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 865,439.5 мянган төгрөгөөр буюу 53.0 хувиар буурсан байна. Энэ нь ковид цар тахалтай холбоотой хичээл сургалтын хэвийн үйл ажиллагаа алдагдаж элсэлт багассанаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 644,407.5 мянган төгрөгөөр буюу 43.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор танхимын хичээл сургалтын үйл ажиллагаа зогсон, цахим хэлбэрээр явагдаж байгаагаас шалтгаалжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,402,497.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,402,497.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Удирдах Зөвлөлийн хурлаар баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 1,402,497.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 519,665.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 124,916.4 мянган төгрөг, төсөл хөтөлбөрөөс 36,746.3 мянган төгрөг, Боловсролын зээлийн сангаас 135,593.3 мянган төгрөг, шугамын зээлээс 250,117.2 мянган төгрөг, харилцахын хүүгийн орлого 379.5 мянган төгрөг, нийт 1,067,421.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,133,455.4 мянган төгрөгийг зарцуулж мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,133,455.4 мянган төгрөг буюу 81.0 хувьтай байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 168 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 116 мэдээлэл, хугацаа хоцорсон 52 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 гүйлгээний нийт 51,096.3 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцорч байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 619,279.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 619,279.2 мянган төгрөгийн зөрчилд 1,687.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 30,130.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 587,460.9 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 31,818.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 31,818.3 мянган төгрөгийн зөрчилд 1,687.9 мянган төгрөгийн төлбөрийн акт 2 тогтоож, 30,130.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 317.9 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хууль Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

- Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийг НДШ болон ХХОАТ-ын тайлантай тулгахад 1 дүгээр сарын цалинг олгохдоо 1,370.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхар эдлүүлсэн байгаа нь ХХОАТ-ын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д Суутган төлөгч нь албан татвар төлөгчид энэ хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ гэсэн заалттай зөрчилдөж байна” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

- Тайлант хугацаанд гарсан зардлаас 30,130.4 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 587,460.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Үндсэн үйл ажиллагааны орлого болох сургалтын орлогыг нарийвчлан тооцоолох нөхцөл боломж бүрдээгүй тул дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Авлагын данстай холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:*

2019-2020 оны хичээлийн жилд 587,460.9 мянган төгрөгийн оюутны сургалтын төлбөрийн авлагыг хувь хүнээс авах авлагад бүртгэсэн байна.

1.2. *Эрсдэл:*

Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв бодтой мэдээллээр хангахгүй байх..

1.3. *Өгсөн зөвлөмж:*

Дээд шатны байгууллагад нэгтгэх, бусад ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг сургуулийн авлагын ангилалтай тохирохгүй байна. Оюутнудаас авах авлагыг дээд шатны байгууллагын жишиг НБББББ-ын дагуу төлбөртэй үйлчилгээний авлага дансанд бүртгэх.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Хэрэгжүүлж ажиллана

НБББББ-тай холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:*

Одоо ашиглагдаж байгаа НБББББ нь стандарт, холбогдох хууль журам зааврыг хангаж чадахгүй байна.

1.2. *Эрсдэл:*

НББ-д бүртгэл хөтлөлт, тооцооллын алдаа гарах...

1.3. *Өгсөн зөвлөмж:*

Дээд шатны байгууллагын шинэчлэн боловсруулж байгаа НБББББ-ыг жишиг болгон өөрсдийн үйл ажиллагааны онцлогт тохируулан НБББББ-тай болох.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Хэрэгжүүлж ажиллана

Зардлын данстай холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:*

Шатахууны зардлын тооцоололтыг тулгах явцад тухайн байгууллагын эзэмшилд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл нь спидометрийн заалт ажиллахгүй байгаа гэсэн тайлбарыг ирүүлж байсан.

1.2. *Эрсдэл:*

Зардлыг үнэн зөв тооцоолох боломжгүй болох.

1.3. *Өгсөн зөвлөмж:*

Дээрх асуудлыг шийдвэрлэн шатахууны зарцуулалтыг тооцох анхан шатны баримтын бүрдлийг хангах.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.03.15</b>	Аудитын нэр: <b>Дорнод аймгийн Дорнод Их сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>ДОА-2021/41/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Дорнод аймгийн Дорнод Их сургууль</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Шилэн дансны цахим системд 116 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 52 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Мөн дараах мэдээллүүдийг хугацаа хоцорч байршуулсан байна. Үүнд: 1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр) 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) 1-6 сар, 9 сар, 3-р улирал 3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) 2,6,9 сард 4. Ковид-19 цар тахалтай холбоотой мөнгөн хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ (Сар бүр) 1-7 сар 5. Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ (Сар бүр) 1-7 сар 6. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 1-2 сар 7. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) 2,9 сард 8. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 2,6,9,12 саруудад		Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Э.Ундармаа Б.Гэрэлтуяа
2	Харилцахаас худалдан авалт хийсэн гүйлгээг цахим төлбөрийн баримттай тулгахад 30,130.4 мянган төгрөгийн баримт цахим төлбөрийн системд бүртгэгдээгүй байна.	30,130.4	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Э.Ундармаа Б.Гэрэлтуяа

3	Шатахууны зардалд 4,393.9 мянган төгрөгийн зардал гаргасан ба жишиг нормоор тооцоолоход 317.9 мянган төгрөгийн илүү зарцуулсан байна.	317.9	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Э.Ундармаа Б.Гэрэлтуяа
4	Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийг НДШ болон ХХОАТ-ын тайлантай тулгахад 1 дүгээр сарын цалинг олгоходоо 1,370.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхар эдлүүлсэн байна.	1,370.0	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Э.Ундармаа Б.Гэрэлтуяа
5	2019-2020 оны хичээлийн жилд 587,460.9 мянган төгрөгийн оюутны сургалтын төлбөрийн авлагыг хувь хүнээс авах авлагад бүртгэсэн байна.	587,460.9	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Э.Ундармаа Б.Гэрэлтуяа
6	Одоо ашиглагдаж байгаа НБББББ нь стандарт, холбогдох хууль журам зааврыг хангаж чадахгүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Э.Ундармаа Б.Гэрэлтуяа
7	Шатахууны зардлын тооцоололтыг тулгах явцад тухайн байгууллагын эзэмшилд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл нь спидометрийн заалт ажиллахгүй байгаа гэсэн тайлбарыг ирүүлж байсан.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Э.Ундармаа Б.Гэрэлтуяа
<b>ДҮН</b>		<b>619,279.2</b>			